



36Page



37Page



38Page



39Page

Өвчнийг эдгээсэн нь

-Jesus Heals (The Paralyzed Man)-

- Тайлбарлагч** Есүс өвчтэй хүнийг эдгээсэн гэдгийг мэдэхгүй хүн Израилд бараг байхгүй байв. Олон хүн Түүнийг гайхшран дагадаг байв. Нэгэн өдөр Есүс Капернаум тосгонд иржээ.
- Хүмүүс** Есүс Христ супер од !!!
- Тайлбарлагч** Тэр тосгонд ганцаараа явж чадахгүй, хоолоо ч өөрөө идэж чаддаггүй саа өвчтэй хүн байдаг байлаа.
- Саа өвчтөн** Би алхаж ч чадахгүй байж яаж Есүстэй уулзахаар явахын бэ? Энэ бүтэхгүй зүйл.
- Найзууд** Бид нар тусалъя.
-
- Тайлбарлагч** Саа өвчтэй найзаа, найзууд нь Есүс уруу дагуулж явахаар болов. Найзууд нь бат бөх гэгчийн даавуу болон шон бэлдээд дамнуурга хийв. Чү бай! Чү бай! Бүх хүчээ дайчлан Есүсийн байгаа газар уруу дагуулж очив.
-
- Тайлбарлагч** Гэтэл маш олон хүн цугласан учир гэр лүү орж чадахгүй байв. Шувуу шиг далавчтай байсан бол нисээл орчих байлаа...
- Найз1** Далавчаа ??? Тэр чинь харин сайхан санаа !!!
- Тайлбарлагч** Айн ???
- Найз2** Тийм ээ. Бид нар дээшээ гарна.!!!
- Тайлбарлагч** Айн??? Юу гэсэн бэ?
-
- Тайлбарлагч** Хүүе юу болох нь энэ вэ? ... Найзууд нь Есүсийн байгаа байшингийн дээврийг нүхлэж эхлэв.
- Эрэгтэй1** (Чимээ гартал) Хөөх!!! Тийшээ хардаа!
- Эрэгтэй2** Дэ..дэ.. дээвэр нурж байна.
- Эрэгтэй3** Аааа...
- Тайлбарлагч** Тэнд байсан хүмүүс бүгд гайхан тааз руу харцгаав. Энэ үед найзууд нь дамнуурганд олс уян өвчтэй найзыгаа Есүсийн өмнө буулгав. Болгоомжтой...
- Тайлбарлагч** Ингээд саа өвчтэй найз нь Есүсийн өмнө очив.



40Page

-
- Тайлбарлагч** Есүс найзуудынх нь итгэлийг харан магтаж, тэгээд саа өвчтэй найзад нь хандан хэлэв.
- Есүс** Чиний бүх гэмийг уучиллаа. Саа өвчтэй хүн би чамд хэлж байна. Бос дэвсгэрээ аваад гэртээ харь.
- Тайлбарлагч** Гэтэл өнөөх саа өвчтэй хөдөлж ч чадахгүй байсан хүн, гэнэт босож ирэв. Эдгэрсэндээ баярлаж Есүст талархав.
- Саа өвчтөн** Би ингэж хөдөлж бүр алхаж ч чадаж байна. Есүс ээ, үнэхээр их баярлалаа. баярлалаа.
- Тайлбарлагч** Тэр Бурханд алдарыг өргөн, хэвтэж байсан дэвсгэрээ аваад гэрийн зүг явжээ. Тэнд байсан хүмүүс бүгдээрээ мэл гайхахын зэрэгцээ Бурханыг алдаршуулж байлаа.